


ШҮҮХИЙН ХЭРГИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГЫН МЭДЭЭ

2025 ОН 2 САР

№49

“ Шүүхийн ерөнхий зөвлөлийн Хэргийн хөдөлгөөний удирдлага, статистикийн газар 2025 оны 2 дугаар сарын хэргийн хөдөлгөөний мэдээг нэгтгэн, улсын хэмжээн дэх эрүү, иргэн, захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхүүдийн хэргийн хөдөлгөөний мэдээг танилцуулж байна. ”


ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ



2025.02.01-2025.02.28-ны өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт **9713** хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн **1507**

хэрэг, иргэний **7926** нэхэмжлэл, захиргааны **280** нэхэмжлэл хүлээн авсан байна.

ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ




2025.02.01-2025.02.28-ны өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх анхан шатны шүүхүүд нийт **6397** хэрэг хянан шийдвэрлэснээс эрүүгийн **1374**, иргэний **4881**, захиргааны **142**

хэрэг хянан

шийдвэрлэсэн байна.

2025 ОНЫ 2 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭ



ЭРҮҮГИЙН

Хүлээн авсан нийт хэрэг

1507

ХЭРЭГ

Дүүргийн анхан шатны шүүх

748

49.6%

ИРГЭНИЙ

Хүлээн авсан нийт нэхэмжлэл

7926

ХЭРЭГ

Дүүргийн анхан шатны шүүх

5298

66.8%

ЗАХИРГААНЫ

Хүлээн авсан нийт нэхэмжлэл

280


ХЭРЭГ

Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх

165

58.9%

АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхийн нийт хүлээн авсан хэрэг, нэхэмжлэлийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Захиргааны нэхэмжлэл 68 буюу **32** хувиар, иргэний нэхэмжлэл 1716 буюу **27.6** хувиар, эрүүгийн 356 буюу **30.9** хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Дүүргийн анхан шатны шүүхүүдийн 2025 оны 2 дугаар сарын нэгдсэн тайлан мэдээнээс үзвэл Дүүргийн эрүү, иргэний хэргийн хялбар ажиллагааны тойргийн шүүх 2696 нэхэмжлэл, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүх 315 хэрэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх 165 нэхэмжлэл хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.

Харин Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 112 нэхэмжлэл хүлээн авсан, Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 18 хэрэг хүлээн авсан байна.

Орон нутаг дахь анхан шатны шүүхүүдийн хувьд Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх 260 нэхэмжлэл, Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 77 хэрэг, Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 16, Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 15 нэхэмжлэл тус тус хүлээн авсан байгаа нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх 18 нэхэмжлэл, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх тус бүр 4 хэрэг, Булган, Сүхбаатар, Орхон, Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2 нэхэмжлэл хүлээн авсан нь бусад


аймгуудтай харьцуулахад хамгийн бага үзүүлэлттэй байна.

Иргэний хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **7926** нэхэмжлэлийн **5298** буюу **66.8%**-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.


Захиргааны хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **280** нэхэмжлэлийн **165** буюу **58.9%**-ийг Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх хүлээн авсан байна.

Эрүүгийн хэргийн шүүхийн хувьд хүлээн авсан нийт **1507** хэргийн **748** хэрэг буюу **49.6%**-ийг Дүүргийн анхан шатны шүүхүүд хүлээн авсан байна.

2025 ОНЫ 2 САРЫН БАЙДЛААРХ АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭ




АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРГИЙН МЭДЭЭГ ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕИЙНХТЭЙ ХАРЬЦУУЛБАЛ



Улсын хэмжээнд анхан шатны шүүхээр нийт хянан шийдвэрлэсэн хэргийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

Захиргааны хэрэг **1** буюу **0.9** хувиар буурсан. Иргэний хэрэг **263** буюу **5.6** хувиар, Эрүүгийн хэрэг **382** хэрэг буюу **38.5** хувиар тус тус өссөн үзүүлэлттэй.

ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШИЛСОН БАЙДАЛ



Иргэний хэргийн шүүхийн хувьд 4085 шүүх хуралдаан товлон зарласнаас 1486 шүүх хуралдаан хойшилсны 90% нь хэргийн оролцогчоос, 10% нь шүүхээс шалтгаалсан байна. Хэргийн оролцогч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгчтэй шүүх хуралдаанд оролцох, нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан гэсэн шалтгаанаар шүүх хуралдаан хойшлуулсан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд 528 шүүх хуралдаан товлон зарласнаас 375 шүүх хурал хойшилсны 91.1% нь хэргийн оролцогчоос, 8.9% нь шүүхээс шалтгаалсан байна. Хүсэлтийг хүлээн авч шүүх хуралдааныг хойшлуулсан гэсэн шалтгаан нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Харин эрүүгийн хэргийн шүүхийн хувьд 2609 шүүх хурал товлон зарласнаас 835 шүүх хурал хойшилсон 93.2% нь хэргийн оролцогчоос, 6.8% нь шүүхээс шалтгаалж хойшилсон байна.


Товлосон 7209 **НИЙТ ШҮҮХ ХУРАЛДААНЫ**
Хойшилсон 3124 **43.3%**

ХУГАЦАА ХЭТРЭЛТ


Улсын хэмжээнд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт 22684 хэрэг байгаагаас 6992 хэрэг буюу 30.8%-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 19687 хэргийн 6463 хэрэг буюу 32.8%, Захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 1641 хэргийн 501 хэрэг буюу 30.5% тус тус хугацаа хэтрэлттэй байна.


Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа 1356 хэрэгт хугацаа хэтэрсэн хэрэг байхгүй байна.



2025 ОНЫ 2 САРЫН БАЙДЛААРХ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД



ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ




Улсын хэмжээнд анхан шатны шүүх нийт 469 таслан сэргийлэх арга хэмжээний санал хүлээн авснаас 409 шийдвэрлэсэн байна. Үүнээс тодорхой үйл ажиллагаа цагдан хорих хугацаа сунгах явуулах, албан үүргээ 178 шийдвэрлэсэн байна. биелүүлэхийг түдгэлзүүлэх 1, Харин барьцаа авах таслан хязгаарлалт тогтоох 89, сэргийлэх арга хэмжээг яллагдагчаар цагдан хорих 84, шийдвэрлээгүй байна.

ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ



Улсын хэмжээнд анхан шатны торгох шийтгэл 3652, оногдуулсан байна. Харин шүүх нийт 5995 зөрчлийн хэрэг баривчлах шийтгэл 1270, эрх нийтэд тустай ажил хийлгэх хүлээн авснаас 5231 хэргийг хасах шийтгэл 2526 хүн, шийтгэлийг хүн, хуулийн шийдвэрлэсэн байна. Үүнээс хуулийн этгээдэд тус тус этгээдэд оногдуулаагүй байна.

2 ДУГААР САРЫН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН НЭГДСЭН МЭДЭЭ



2 ДУГААР САРЫН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН НЭГДСЭН МЭДЭЭ

ХҮЛЭЭН АВСАН ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ




2025.02.01-2025.02.28-ны өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх давж заалдах шатны шүүхүүд нийт **587** хэрэг, нэхэмжлэл хүлээн авснаас эрүүгийн **311** хэрэг, иргэний **186** хэрэг, захиргааны **90** хэрэг, нэхэмжлэл хүлээн авсан

ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ХЭРЭГ



2025.02.01-2025.02.28-ны өдрийн байдлаар Улсын хэмжээн дэх давж заалдах шатны шүүхүүд нийт **541** хэрэг хянан шийдвэрлэснээс эрүүгийн **263**, иргэний **174**, захиргааны **104** хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

ШҮҮХ ХУРАЛДААН ХОЙШИЛСОН БАЙДАЛ



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 414 шүүх хуралдаан товлон зарласнаас 61 шүүх хуралдаан хойшилсон. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 289 шүүх хуралдаан товлон зарласнаас 38 шүүх хуралдаан хойшилсон. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн хувьд 208 шүүх хуралдаан товлон зарласнаас 38 шүүх хуралдаан тус тус

ХУГАЦАА ХЭТРЭЛТ

Улсын хэмжээнд хянан шийдвэрлэх ажиллагаанд нийт **479** хэрэг байгаагаас **8** хэрэг буюу **1,6%**-ийг хугацаа хэтэрсэн хэрэг эзэлж байна.

Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **143** хэргийн **2** хэрэг буюу **1,3%**, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа **106** хэргийн **3** хэрэг буюу **2,8%**, Эрүүгийн хэргийн давж заалдах шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллаганд байгаа 230 хэргийн **3** хэрэг буюу **1,3%** нь тус тус хугацаа хэтрэлттэй байна.



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2024 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮН МЭДЭЭ ГАРЛАА.

Монгол Улсын шүүх 2024 оны бүтэн жилд 143824 хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүх 2024 онд эрүүгийн 14682 хэрэг, иргэний 73727 хэрэг, захиргааны 2436 хэрэг, зөрчлийн 45183 хэрэг нийт 136028 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 705 хэргээр буюу 5 хувиар, иргэний хэрэг 10320 хэргээр буюу 16.3 хувиар, захиргааны хэрэг 65 хэргээр буюу 2.7 хувиар, зөрчлийн хэрэг 18935

хэргээр буюу 73.4 хувиар тус тус өссөн байна. Давж заалдах шатны шүүх 2024 онд эрүүгийн 2611 хэрэг, иргэний 2974 хэрэг, захиргааны 809 хэрэг, зөрчлийн 829 хэрэг нийт 7223 хэргийг хянан шийдвэрлэжээ. Давж заалдах шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 396 хэргээр буюу 17.9 хувиар, захиргааны хэрэг 63 хэргээр буюу 8.4 хувиар, зөрчлийн хэрэг 106 хэргээр буюу 14.7 хувиар тус тус өссөн бол иргэний хэрэг 136 хэргээр буюу 4.4 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Хяналтын шатны шүүх 2024 онд эрүүгийн 144 хэрэг, иргэний 321 хэрэг, захиргааны 138 хэрэг нийт 603 хэргийг хянан шийдвэрлэсэн байна. Хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 20 хэргээр буюу 12.2 хувиар буурсан бол иргэний хэрэг 77 хэргээр буюу 31.6 хувиар, захиргааны хэрэг 38 хэргээр буюу 38 хувиар өссөн дүнтэй гарчээ. Монгол Улсын шүүхээс 2024 онд нийт 56 тэрбум 8 сая 254 мянга 265 төгрөгийг төрийн санд оруулахаар шийдвэрлэжээ.